



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 247,515,277.00 (хоёр зуун дөчин долоон сая таван зуун арван таван мянга хоёр зуун далан долоо) төгрөгийн балансын үнэ, 145,415,224.65 (нэг зуун дөчин таван сая дөрвөн зуун арван таван мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын захиргааны захирал Б.Бат-Орших, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001551

16-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 23 ны өдрийн
3.1 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХҮЙН ХАЛХГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ БҮСИЙН ЗАХИРГААНЫ БАЛАНСААС
ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
(төгрөг)								
Байгууламж								
1	Цахилгааны агаарын шугам /15мв, 13000 м, трансформатер 380в/	3/24/2017	ш	1	247,515,277	247,515,277.00	145,415,224.65	102,100,052.35
	Нийт дүн			1		247,515,277.00 (хоёр зуун дөчин сая таван зуун арван мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг далан долоо)	145,415,224.65 (нэг зуун дөчин таван сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун хорин дөрвөн төгрөг жаран таван мөнгө)	102,100,052.35 (нэг зуун хоёр сая нэг зуун мянга хоёр гучин таван мөнгө)